



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/420

Булган сум

Нийтийн шугаман бүжгийн “Жигүүр”,  
“Цоглог” хамтлаг, “Сайхан цаг” бүжгийн холбоонд  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ахмад наснуудын дунд зохион байгуулагдсан 2025 оны нийтийн шугаман бүжгийн улсын уралдаанд амжилттай оролцсон Булган сумын Ахмадын хорооны дэргэдэх 70-аас дээш насны ахмадуудын “Жигүүр”, 50-иас дээш насны ахмадуудын “Цоглог” хамтлагийн тэмцээн уралдааны зардалд тус бүр 2,000,000 (хоёр сая) төгрөг, “Сайхан цаг” бүжгийн холбоонд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

